



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/13


Улаанбаатар хот

Спорт наадам зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 12.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хаврын баяр-2016" спорт наадмыг 2016 оны 03 дугаар сарын 05, 11-ний өдрүүдэд байгууллагын нийт ажилтнуудын дунд зохион байгуулсугай.
2. Спорт наадмыг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, холбогдох зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Спорт наадмыг зохион байгуулахад шаардагдах 8 900 000 /Найман сая есөн зуун мянган/ төгрөгийг нийгмийн арга хэмжээний зардлаас тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тушаалын хэргжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа дэмжих асуудал хариуцсан Орлогч дарга /С.Майнбаяр/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН

2130300023